

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 11
ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	7-32
	1.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	7-11
	2.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	11-30
	3.Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	30-32

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хамтарсан хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Э.Батшугар, Н.Ганибал, Ц.Идэрбат,
Л.Мөнхбаатар, Х.Нямбаатар, Ч.Ундрал, Б.Пүрэвдорж;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Б.Дэлгэрсайхан, Ж.Чинбүрэн.
Тасалсан: Б.Саранчимэг.

**Нэг.Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар
2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга Д.Ганзориг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Б.Хонгорзул, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулга болон эцсийн хувилбарын төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Учрал гишүүн танилцуулна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас болон гишүүдээс санал гаргаагүй болно оо. Төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засваруудыг хийж төсөлд тусгасан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэж та бүхэнд тараасан.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Учрал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагчид.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болор-Эрдэнэ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Ган-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээллийн технологийн газрын дарга, Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Эрдэнэ Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга, Ганзориг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга, Билэгдэмбэрэл Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга, Тэнгис Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга, Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн

бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Сүрэнхорол Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Тамир Мэдээллийн технологийн операторуудын ассоциац гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна аа.

Танилцуулга болон төслийн эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна.

Амарсайхан гишүүн хуралдаа ирж байна. Ирцдээ орж байна.

Асуулт асуух гишүүн байхгүй байгаа учраас. Энхбаяр гишүүн асуултаа асууя. Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Б.Энхбаяр: Бид нар одоо Нийтийн мэдээллийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийж байна. Ингээд шувтрах маягтай, батлагдах маягтай болж байна аа. Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байх үед одоо Мөнх-Оргил дарга, Сүхбаатар гишүүн, миний хувьд бас хэлж байсан нэг асуудал бол энэ Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчлөхгүйгээр, энэ хууль бол бас амилахгүй ээ гэдгийг бол хэлж байсан. Тэр албаны нууцын тухай хуулийг өөрчлөхгүй бол хуучин Улсын Их Хурал бол энэ төрийн нууцын жагсаалтаа баталдаг байсан юм аа. Нууцыг. Юуг төрийн нууц гэх вэ, нууц дотроо онц чухал нууц, маш нууц, нууц гэсэн энэ 3 ангиллын алинд байх вэ гэдгийг жагсаалт гаргаад Улсын Их Хурлын тогтоолоор баталдаг байсан юм.

Тэгээд энэ төрийн болон албаны нууцын тухай хуулийг батлаад одоо энэ Улсын Их Хурал юуг нууц, нууц биш гэдгийг мэддэг нь ингээд Улсын Их Хурлын хяналтаас гаргаад хаячихсан. Ингэж гаргаж аваад юу болсон бэ гэхээр одоо бол Засгийн газар юуг нууцлах вэ, нууцлахгүй вэ гэдгээ ингээд өөрсдөө мэддэг болчихсон. Одоо улсын нууцыг нэг өдөр гаргах уу, улсын нууцад оруулах уу гэдгийг өөрсдөө мэдэж байгаа.

Үүний цаана юу явж байна вэ гэхээр улсын нууцтай холбоотой төрийн худалдан авалтын ажиллагаа бол тендер зарлагддаггүй. Ингээд томоохон хэмжээний төслүүд, томоохон хэмжээний мөнгөн дүнтэй асуудлуудыг нууцад оруулаад тендергүйгээр ингэж хийдэг ийм зуршил бий болжээ. Үүний цаана их хэмжээний мөнгө одоо авлигын асуудал мэдээж том хэмжээний авлигын асуудал яригдана. Нөгөө талаар энэ төрийн байгууллагууд энэ Улсын Их Хурал нууцын жагсаалтыг баталдаг байх үед албаны нууц гээд 100 гаруй нууцтай байсан юм байна лээ. 100 гаруй төрлийн. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтэд мониторинг хийгээд үзсэн чинь Улсын Их Хурлаас энэ нууцын жагсаалтыг баталдгийг гаргаснаас хойш одоо энэ албаны нууц чинь дөрөв таван зуу болчихсон гээд байгаа байхгүй юу. Нөгөө иргэдийн мэдэх эрх бүр байхгүй болсон. Мэдээлэл чөлөөтэй авах эрх бас байхгүй болсон. Яг энэ албаны нууц гэдгээр. Албаны нууцыг хэн тогтоож байна вэ гээд тэгсэн чинь байгууллагын дарга өөрөө тогтоож байгаа. Төрийн байгууллагын дарга өөрөө үүнийг албаны нууц гэвэл тэгээд л нууц. Хүссэнээрээ нууцалдаг. Тэгээд иргэд янз бүрийн ийм чөлөөтэй мэдээлэл очоод авъя гэхээр ингээд албаны нууц аа гээд ингээд зогсчихдог. Бүр нэг ямар ч нууцлах шаардлагагүй.

Би бол хэлэлцэх эсэхийг асуудлыг хэлэлцэж байхад асууж байсан шүү дээ. Төрийн өмчийн реформ хийх ёстой, төрийн өмчийн компанийн реформ хийх ёстой гээд ноднин жил сайд нараас асуулга тавиад мэдээлэл авсан чинь нууцын тамгатай мэдээлэл ирүүлчхэж байгаа юм. Тэр мэдээлэл нь юу вэ гэхээр тэр

төрийн өмчийн компанийн бүтэц, орон тоо, цалин байхгүй юу. Үгүй ээ, энэ нууц юм уу. Одоо Улсын Их Хурлын гишүүдэд ингээд нууцын тамга дараад ирүүлчхэж байгаа байхгүй юу. Энэ албаны нууц гээд. Тэгээд би тэр орон тоог зарлавал би одоо 2-8 жилийн хорих ял авах гэж байгаа байхгүй юу. Тэр байгууллагын зүгээр өөрөө даргын нууц тамга тарсны төлөө.

Тийм учраас энэ албаны нууц, төрийн нууцын хуулийг цуг бол өөрчлөх ёстой. Мэдээж Засгийн газар бол хамт оруулж ирж ирээгүй. Тэгэхээр энэ баталсны дараа үүнийг дагасан Засгийн газарт чиглэл өгмөөр байна аа. Төрийн болон албаны нууцын хуулийг яаралтай оруулж ирж үүнтэй холбоотойгоор батлах.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн нэлээн чухал асуудал хөндөж байна аа. Манай ажлын хэсгийн ахлагч хариулчих уу? Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энэ өмнөх анхны хэлэлцүүлгийн үеэр бас гишүүд энэ саналыг хэлж байсан. Тэгээд 2016 оны тэр төрийн албаны болон нууцын хуулиар яг энэ тухайн байгууллага нь өөрсдөө аливаа мэдээллийг нууцдаа хамааруулаад. Энэ бол нууцад хамаарах мэдээлэл юм аа гээд одоо дарчихдаг ийм эрх зүйн орчин байсан. Үүнийг өөрчлөх шаардлагатай гээд гишүүд бол нэлээн олон санал гаргасан. Тэгэхээр энэ хуулиар болбол нэлээд асуудлыг хөндөж байгаа нь хэдийгээр тухайн байгууллага тэр өөрийгөө мэдээллийг нууцад хамааруулсан байсан ч энэ хуулиар энэ 67 мэдээллийг шууд нээлттэй болгож байгаа. Тэр хууль дээр биччихсэн энэ 67 мэдээллийг ямар ч байгууллага, цаашдаа энэ 2016 оны хууль нь хэрэгжиж байсан байсан ч үүнийг нууц гээд дарах ямар ч бололцоо болбол байхгүй. Жишээ нь, 8.4 дээр тэр нөгөө төсвийн гүйцэтгэл, бүтэн жилийнх нь тайлан, нөгөө тусгай зөвшөөрлүүд. Одоо энэ тусгай хамгаалалттай газар нутгийн, одоо хэн авсан байгаа нь хүртэл энэ хуулиар болбол нээлттэй явуулна. Нөгөө орон сууцыг худалдаж байгаа орон сууцыг комисс хүлээж авахад улсын комиссын шийдвэр гардаг. Тэр комиссынх нь шийдвэр хүртэл нээлттэй болж байгаа. Тэгэхээр энэ 67 мэдээллийг ингэж нээлттэй болгосноороо болбол байгууллагууд түүнийг нууцаар хаах бололцоогүй болчихож байгаа. Энэ 67 мэдээллийг мэдээллийг боловсруулж цуглуулж байгаа тэр мэдээлэл хариуцагч тал, олон нийтийн хэвлэл мэдээлэл, зар одоо хэвлэл мэдээллээр өөрийн албан ёсны тэр вэб хуудсаараа олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээж байгаа. Тэгэхээр өмнө нь бид хэлж байсан. Тэр Улсын бүртгэлийн хууль батлагдсаны дараа хууль хэрэгжээд эхэлсэн. Опен дата гээд оронгуут одоо төрийн бус байгууллагууд, хуулийн этгээдүүд хэн эзэмшиж байгаа тэр эзэмшиж байгаа э хуулийн этгээд, тэр мэдээллүүд нь ил тод болсонтой яг ижил. Энэ 67 мэдээлэл нээлттэй болсноороо тухайн байгууллагууд олон нийтэд нээлттэйгээр энэ мэдээллүүдээ тавьж эхэлнэ ээ. Энэ бол үүрэгтэй болж байгаа.

Тэгэхээр энэ 67 мэдээллийг болбол нууцлах бололцоо одоо дахиж байхгүй болно оо гэсэн үг. Одоо жишээ нь маш их хэл ам дагуулдаг, худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ, аудит, тэгээд л нөгөө бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнээс гарсан шийдвэрүүд. Энэ шилэн дансны хөтлөлтүүд, цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагууд, төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт, Засгийн газрын гадаад улс зээл, тусламжуудын талаарх мэдээлэл. Нөгөө улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төсвийн гүйцэтгэл, аудит хийсэн нэгдсэн тайлан, концессын жагсаалт,

тэгээд л мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа гээд. Ингээд ерөөсөө энэ 67 мэдээлэл ил тод болсноороо энэ нийтийн мэдээлэл болбол аль нь нээлттэй байх юм. Аль нь хязгаартай хаалттай байх юм гэдэг нь маш ойлгомжтой болж байгаа.

Тэгэхээр энэ 67 мэдээллийг хаах ямар нэгэн тамга дараад нууцлах бололцоо алга байхгүй ээ гэсэн үг. Гэхдээ цаашдаа бол бас энэ 2016 оны хуульд болбол өөрчлөлт оруулах зайлшгүй бол шаардлага үүсэж байгаа юм. Тэгэхээр энэ Нийтийн мэдээллийн хууль болбол хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг ч, тоон гарын үсгийн хуулийг ч, Кибер аюулгүй байдлын хуулийг ч гэсэн яг үндэс суурь нь болбол болж байгаа. Тийм учраас цаашдаа бол бас тэр 2016 оны хуульдаа өөрчлөлт оруулах шаардлагатай байх аа гэж үзэж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн хариуллаа.

Асуулт тасалсан. Дараагийнхад нь асууж болно оо.

Ингээд Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хороонд танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Их Хурлын гишүүн Учрал гишүүн, ажлын хэсгийн ахлагч танилцуулна аа.

Дараагийн асуудалдаа оръё.